



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хашаат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/11/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.21 № 150
танай _____-ны № _____-г

АРХАНГАЙ АЙМГИЙН
ХАШААТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.АНХБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Хашаат сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Сумын засаг даргын санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,213,239.8 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1,626,092.1 мянган төгрөгийг зарцуулж, 587,147.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хашаат сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 78 арга хэмжээг 100 хувь, 11 арга хэмжээ 90 хувь, 11 арга хэмжээг 70 хувь, 5 арга хэмжээг 50-аас доош хувийн гүйцэтгэлтэй биелүүлж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс **76.6** хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|--------------|--|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 862,651.6 | 716,889.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 670,540.2 | 597,352.3 |
| 33 | АВЛАГА | 139,354.7 | 66,907.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 52,756.7 | 52,630.1 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,632,418.6 | 2,106,610.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,632,418.6 | 2,106,610.6 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,590,677.6 | 2,064,944.6 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 41,741.0 | 41,666.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,495,070.1 | 2,823,500.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,495,070.1 | 2,823,500.5 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,495,070.1 | 2,823,500.5 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 579,400.5 | 579,400.5 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,702,195.7 | 2,030,626.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 213,474.0 | 213,474.0 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,495,070.1 | 2,823,500.5 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------------|---|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,801,214.6 | 1,956,228.8 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 360,974.0 | 577,260.2 |
| 110 | Орлогын албан татвар | 241,830.4 | 488,997.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 241,711.9 | 488,878.0 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 118.5 | 119.7 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 111,737.7 | 82,850.5 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 7,405.8 | 5,412.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 661,314.3 | 643,951.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 661,314.3 | 643,951.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 778,926.3 | 735,017.6 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 920,181.3 | 1,244,141.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 912,474.3 | 1,238,977.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 910,449.4 | 1,195,734.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 404,273.5 | 615,175.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,292.0 | 76,009.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,998.9 | 132,932.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,550.7 | 37,165.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,389.4 | 31,362.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,153.0 | 17,888.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 166,485.5 | 39,562.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 214,306.3 | 245,639.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,025.0 | 43,243.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,707.0 | 5,163.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 881,033.2 | 712,087.6 |

| | | | |
|----|--|-----------|-----------|
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 354,486.1 | 383,657.3 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 526,547.1 | 328,430.3 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|---|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,381,243.7 | 1,557,826.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 360,974.0 | 577,260.2 |
| 110 | Орлогын албан татвар | 241,830.4 | 488,997.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 241,711.9 | 488,878.0 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 118.5 | 119.7 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 111,737.7 | 82,850.5 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 7,405.8 | 5,412.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,253.4 | 2,686.0 |
| 1181 | Газрын төлбөр | 4,152.4 | 2,726.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 282,613.4 | 245,548.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 282,613.4 | 245,548.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 737,656.3 | 735,017.6 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 769,832.1 | 1,060,384.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 769,832.1 | 1,060,384.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 767,807.1 | 1,016,600.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 404,273.5 | 615,175.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,292.0 | 76,009.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,724.9 | 136,442.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,360.8 | 33,393.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,423.8 | 31,572.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,153.0 | 17,888.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 166,485.5 | 42,562.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 87,093.5 | 63,556.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,025.0 | 43,784.4 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 611,411.6 | 497,441.8 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 469,544.7 | 570,629.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 469,544.7 | 570,629.7 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 469,544.7 | 570,629.7 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (469,544.7) | (570,629.7) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 141,866.9 | (73,187.9) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 528,673.3 | 670,540.2 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 670,540.2 | 597,352.3 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---------------------|--|------------------------|
|------|---------------------|--|------------------------|

| | | | |
|----|--|--------------------|--------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,945,346.5 | 1,945,346.5 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 23,176.5 | 23,176.5 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,968,523.0 | 1,968,523.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 526,547.1 | 526,547.1 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,495,070.1 | 2,495,070.1 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,495,070.1 | 2,495,070.1 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,495,070.1 | 2,495,070.1 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 328,430.3 | 328,430.3 |
| 20 | 2024 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл | 2,823,500.4 | 2,823,500.4 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------|--|--------------------|--------------------|--------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,213,239.8 | 1,626,092.1 | 587,147.7 | 73.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,260,413.3 | 1,086,585.0 | 173,828.3 | 86.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,215,129.3 | 1,042,800.5 | 172,328.8 | 85.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 722,490.4 | 615,175.6 | 107,314.8 | 85.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 90,294.6 | 76,009.5 | 14,285.1 | 84.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 148,192.8 | 136,442.0 | 11,750.8 | 92.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 34,548.2 | 33,393.4 | 1,154.8 | 96.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,200.0 | 31,572.2 | 2,627.8 | 92.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,970.1 | 17,888.0 | 82.1 | 99.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 81,787.6 | 67,557.0 | 14,230.6 | 82.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,645.6 | 64,762.8 | 20,882.8 | 75.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,284.00 | 43,784.40 | 1,499.6 | 96.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 45,284.00 | 43,784.40 | 1,499.6 | 96.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 618,722.40 | 539,507.20 | 79,215.2 | 87.2 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 334,104.1 | - | 334,104.1 | - |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,213,239.8 | 1,675,091.0 | 538,148.8 | 75.7 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,482,105.2 | 1,598,058.2 | (115,953.0) | 107.8 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 731,134.6 | 77,032.8 | 654,101.8 | 10.5 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 313,537.4 | (313,537.4) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 362,536.3 | (362,536.3) | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 26 | 23 | 3 | 88.5 |
| 62 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 26 | 23 | 3 | 88.5 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|---|-----------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 16,102.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 16,102.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,922.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний бусад төлбөр хураамжийн зардал | 1,872.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,049.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,180.6 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 11,180.6 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 16,102.6 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 16,102.6 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **6,748.5** мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 6,355.0 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ✓ Бараа материалын дансанд улсын төсвийн байгууллагын 6,748.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэгдсэн нь УСНББОУС 1, 12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул бараа материалын тайланд залруулга хийлгэлээ.

Мөн аудитаар нийт **23,654.4** мянган төгрөгийн зөрчил² илэрч зөрчил арилгуулах 23,654.4 мянган төгрөгийн ХХС-ийн авлага болон орлоготой холбоотой 3 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 23,654.4 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **24,898.9** мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч хог хаягдлын үйлчилгээний хураамж 3,428,000 төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 100,000 төгрөгөөр нийт 2 нэр төрлийн орлого 3,528,000 төгрөгөөр тасарсан, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах

5.3.2. Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх санд 8 зээлдэгчтэй холбоотой 20,126,400 төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн 20,126,400 төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар холбогдох хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн санг хохиролгүй болгох

5.3.3. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийн дийлэнх хувийг цалингийн сангаас зориулалт бус зарцуулсан зөрчил нь сумын санхүүгийн алба, төрийн сангаас төсөвт байгууллагуудын төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.7-д заасан өдөр тутмын хяналтыг тогтмол хэрэгжүүлж, үр дүнг сайжруулах арга хэмжээг авах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------------------------|---------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Улсын төсөвт байгууллагын бараа материалыг бүртгэсэн | 1 | 6,748.5 | - | - | 1 | 6,748.5 | 1 | 6,748.5 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | |
|----------------------------|-------------|-----------------|---------------|----------|-----------------|----------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
| | | | | | | | | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орлоготой холбоотой | 1 | 3,528.0 | - | - | - | - | 1 | 3,528.0 | - | - | - | - |
| ХХС-тай холбоотой | 1 | 20,126.4 | - | - | - | - | 1 | 20,126.4 | - | - | - | - |
| Дотоод хяналттай холбоотой | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| НИЙТ ДҮН | 3 | 23,654.4 | - | - | - | - | 3 | 23,564.4 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|------------------------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |